

удирдлагын хэвшмэл загвараас салж, оролцоонд тулгуурласан, эрх мэдлийг хуваарилсан удирдлагыг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүний тулд Хууль сахиулах салбарын агентлаг, байгууллагуудын даргын болон захирлын зөвлөлд тодорхой тооны квотоор эмэгтэй албан хаагчийг зөвлөх эрхтэйгээр гишүүнээр ажиллуулах зэргээр албан хаагчдын нийтлэг эрх ашгийг хамгаалах, жөндөрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн салбарын бодлогыг баримталж ажиллах нь зүйтэй юм.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ СУДЛАЛ

ИХ ГҮРНҮҮДИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВ

Г.БАЗАРВААНЬ

ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн
Аюулгүй байдал, стратегийн профессорын багийн
профессор, доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа

Хураангуй: Эдүгээ олон улсын амьдрал таахын аргагүй өөрчлөгдөж, улс төрийн жин нөлөө, эдийн засаг болон батлан хамгаалах хүчин чадавхдаа дулдуйдан үнэт зүйл, ашиг сонирхлоо дэлхийн дэг журамд бататгахын төлөөх тэмцэл их гүрнүүдийн дунд ид өрнөж байна. Энэхүү өрсөлдөөн зарим улсыг өөр хооронд нь ойртуулж буй бол зарим нэгийг нь улам бүр холдуулж буй. Энэ нь “хүйтэн дайн”-аас хойш тогтсон нэг “жанжинт” дэлхийн удирдлагын тогтолцоог ганхуулж, АНУ-ын өнцгөөс бүс нутгийн гүрэн гэгдэж байсан улс орнууд, тухайлбал, ОХУ, БНХАУ, Энэтхэг дэлхийн бодлогод оролцох, өөрийн нөлөөний хүрээг тогтоох, улмаар олон “жанжинт” олон улсын шинэ дэг журмыг *de facto* үүсгээд байна.

Түлхүүр үг: Их гүрэн, олон туйлт, геополитик, хатуу болон зөөлөн хүч, стратеги.

Оршил

Хорьдугаар зууны сүүлийн арван жилээс олон улсын амьдралд тогтсон дэлхийн хэт их гүрний байр сууриа АНУ хадгалан үлдэх "жанжилалын тухайд өрсөлдөөн гэж үгүй гагцхүү АНУ дэлхийд хэрхэн ноёрхох л асуудал бий"-г тунхагласан “Эн тэргүүнд АНУ”¹ гэх бодлогыг баримталж байна.

Алдсан нөлөөгөө дахин тогтоох Кремлийн хүсэл, Орос Өрнөдийн геополитикийн эдээ бээр Крымын хойгт хагарч, тус хойг ОХУ-ын субъект болсноор “хоригийн дайн” эхэлсэн хийгээд хэрэв өнөө үед даган мөрдөх олон

¹ America first

улсын эрх зүйг баримтлах аваас хэзээ эцэслэх нь тун тодорхойгүй байдлыг үүсгээд байна.

БНХАУ-ын эдийн засгийн хүчин чадавх нэмэгдэхийн хэрээр өөрийн нөлөөг бүс нутаг улмаар даян дэлхийд хэрэх “Торгон тор”-ны бодлогыг алгуурхан, үе шаттайгаар хэрэгжүүлж, түүнд учрах саад бэрхшээлийг “мөнгөн бороо”-гоор зохицуулах болов.

Нийгмийн хөгжлийг “спираль” буюу эрчлэх хэлбэрээр өөдөөн дэвждэг хэмээн үздэг бол их гүрнүүдийн харилцаа үүний эсрэг “хөврөх” чиглэлд уруудан хөндийрч. хүйтэрч буй явдал олон улсын аюулгүй байдлыг улам бүр тогтворгүй, эмзэг болгож. дэлхийн дэг журам, хүчний харьцаа хүссэн эс хүссэн өөрчлөгдөхөд хүрч байна.

Энэхүү өгүүлэлд их гүрнүүдийн бодлого, геостратегийн санаачилга Монгол Улсын аюулгүй байдал, гадаад бодлогод

1.1. Олон улсад хэрэгжүүлж буй томоохон санаачлагууд: хугацааны хүчин зүйлс, зорилго, хамрах хүрээ, олон улсын харилцаанд үзүүлэх нөлөөлөл, цаашид өрнөх төлөв байдлын хувилбарууд, үндэслэл

Дэлхийн их гүрнүүдийн санаачлан хэрэгжүүлж буй эдийн засаг, аюулгүй байдлын механизмууд эргээд тэдний ашиг сонирхлыг хамгаалах, нөлөөллөө тогтоох хэрэгсэл /instruments, tools/ болж байна. Үүнд, АНУ-ын “Энэтхэг-номхон далайн стратеги”, ОХУ-ын ЕАЭЗХ, БНХАУ-ын “Бүс ба зам” стратегийг онцолж дараах дэд бүлгийн хүрээнд тайлбарлая.

1.1.1. АНУ-ын “Энэтхэг-Номхон далайн стратеги”

Доналд Трамп Нэгдсэн улсын ерөнхийлөгчөөр сонгогдсоноос хойш түүний гадаад бодлого тодорхойгүй гэх “имиж”-ийг бүрдүүлж тус улсын холбоотон орон ч Вашингтонтой хэрхэн харилцаахаа тодорхойлоход бэрх байдлыг үүсгэж байна. Тэрээр ерөнхийлөгчийн тангарагаа өргөсний дараахан Номхон далай дамнасан түншлэлийн хэлэлцээр /цаашид НДДТ гэх/-ээс АНУ-ыг гаргасан юм, Д.Трамп энэ үйлдлээ НДДТ америкийн ажилчдад сөргөөр нөлөөлөх аюултай хэмээн тайлбарлаж байв. Мөн НАФТА /Хойд Америкийн Чөлөөт худалдааны хэлэлцээр-ийг эргэн харах шаардлатайг мэдэгдсэн юм. Үүгээр тус улсын гадаад бодлогод протекционизм давамгайлах хандлага илэрч байна.

Дэлхийн хоёрдугаар дайны дараагаас явуулж байсан Америкийн бодлого олон талт худалдааны гэрээ, хэлэлцээрээр дамжуулан АНУ-ын эрх ашгийг бэхжүүлэх, дэлхий дахинд тус улсын манлайллыг бэхжүүлэхэд оршиж байв. Иймд НДДТ-ээс гарсан явдал АНУ-д эдийн засагт сөрөг нөлөө үзүүлээд зогсохгүй Ази, номхон далайн бүс нутагт Дэлхийн хоёрдугаар дайны дараа

үүссэн аюулгүй байдлын тогтолцоог ганхуулах аюултай болохыг шинжээчид онцлох болсон юм¹.

НДДТ-ээс АНУ гарсан явдал БНХАУ-д өөрийн санаачилгаа урагшлуулах боломж олгож, стратегийн давуу талыг үүсгэх нөхцөлийг бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл, Ази, Номхон далайн бүс нутагт БНХАУ давамгайлах боломжийг олгож болзошгүй юм. Тодруулбал, Перугийн нийслэл Лима хотод болсон АПЕК-ийн Эдийн засгийн тэргүүн нарын уулзалтын үеэр бүс нутгийн эдийн засгийн иж бүрэн түншлэлийн хэлэлцээр /RCEP/" оролцогчдын анхаарлыг татаж байв.

Бээжингийн зүгээс энэ хэлэлцээрийг урагшлуулна гэдэгт бүрэн итгэлтэй байгаагаа тус улсын ГХЯ-ны хэвлэлийн төлөөлөгч мэдэгдсний^{1 3 4} зэрэгцээ АПЕК-ийн Эдийн засгийн тэргүүн нарын уулзалтын үеэр БНХАУ-ын дарга Си Зиньпин "... Ази, Номхон далайн чөлөөт худалдааны бүс /Free Trade Area of the Asia Pacific-ийг Ази, Номхон далайн бүс нутгийн өнө удаан жилийн хөгжил цэцэглэлтэд чухал ач холбогдолтой стратегийн санаачилга болно ..." хэмээн уг хэлэлцээрийн талаарх БНХАУ-ын байр суурийг илэрхийлсэн юм. Мөн тэрээр Ази, Номхон далайн бүс нутаг нээлттэй, эдийн засагтай институционал механизм байх ёстой тул Ази, Номхон далайн чөлөөт худалдааны бүсийг байгуулахаар тууштай ажиллах хэрэгтэйг онцлон тэмдэглэсэн юм.⁵

Дэлхийн эдийн засгийн төв Ази номхон далайн бүс нутагт шилжиж байгаа энэ үед АНУ уг бүс нутагт байр сууриа алдах явдал тус улсын аюулгүй байдал, цаашдын жанжилалд ихээхэн сөрөг нөлөөтэйг Цагаан ордны тэргүүнд зөвлөхүүд нь сануулах нь дамжиггүй. Иймээс АНУ-ын гадаад бодлого хүссэн хүсээгүй Ази Номхон далайд чиглэнэ.

¹ Nicole Gaouette, CNN "Trump trade deal moves could hurt U.S security posture" /January 26, 2017/ edition. ccn.com/2017/01/26/politics/trump/trump-nafta-tpp/index.htmlsr=fbCCNN012617/trump-nafta-tpp0700AMStoryLink&linkId=33791484 /accessed January 26 2017/

"2011 онд хуралдсан АСЕАН-ы дээд хэмжээний уулзалтын үеэр энэ хэлэлцээрийг анх танилцуулсан юм. Хэлэлцээрийн хүрээнд худалдаа болон зарим нэг үйлдвэрлэлд ногдуулах 95 хувь хүртэл бууруулахаар төлөвлөж байна. Мөн хэлэлцээр байгуулагдвал үйлчилгээ, хөрөнгө оруулалтын бэрхшээлийг багасгахаар төлөвлөж байна. 16 оныг багтаасан энэхүү хэлэлцээрт дэлхийн хүн амын бараг тэн хасгас хамрагдаж, дэлхийн ДНБ-ийн 30 хувь /22,7 их наяд ам.доллар/-ийг үйлдвэрлэх боломжтой. Мөн дэлхийн худалдааны 25 хувийг нийлүүлэх чадвартай юм.

³Xinhua " Spotlight: As TPP withers, RCEP takes center stage at APEC Economic Leader's meeting" /Nov 21,2016/ news.xinhuanet.com/English/2016-11/21/c_135847482.html /accessed Dec 2, 2016/

⁴БНХАУ-ын талаас АПЕК-ийн хүрээнд НДДТ-тэй өрсөлдөхүйц, АНУ-ыг оролцоогүй Ази, Номхон далайн чөлөөт худалдааны бүсийг санаачилсан юм. 2014 оны 11 дүгээр сард Бээжинд хуралдсан АПЕК-ийн дээд хэмжээний уулзалтын үеэр БНХАУ-ын дарга Си Зиньпин энэ хэлэлцээрийн тухай саналаа юэвшүүлж, уулзалтад оролцсон АПЕК-ийн гишүүн орнууд энэ хэлэлцээрийг дэмжихээ илэрхийлсэн болно.

⁵Xinhua " Spotlight: As TPP withers, RCEP takes center stage at APEC Economic Leader's meeting" /Nov 21,2016/ news.xinhuanet.com/English/2016-11/21/c_135847482.html /accessed Dec 2, 2016/

Вьетнамын Да нанг хотноо 2017 оны 11 дүгээр сарын 10-наас 11-ний өдөр болсон АПЕК-ийн уулзалтад үг хэлэхдээ Д.Трамп “Энэтхэг-номхон далайн стратеги”-аа танилцуулав. Ингэхдээ Ази номхон далайн бүс нутагт өсөн нэмэгдэж буй Бээжингийн нөлөөг Энэтхэгийн оролцоотойгоор хумих тактик барьж болзошгүй байна. Хэдийгээр Энэтхэг зэрэг ардчилсан улс, түншүүдээ түлхүү хамааруулж. “Энэтхэг-номхон далайн стратеги” хэмээн томьёолж байгаач энэ стратегийг Хятадыг тогтоон барих зорилго бүхий “дахин тэнцвэржүүлэх бодлого”-ын үргэлжлэл хэмээн үзнэ.

БНЭУ-ын ерөнхий сайд Н.Моди "Дорно руу хандах бодлого" /Act East Policy/ хэрэгжүүлж, Зүүн Азийн орнуудтай бүхий л салбарт харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар Хятадын нөлөөг хязгаарлахыг эрмэлзэж буй. Иймээс Япон, АНУ-ын зүтээс ижил зорилго бүхий "Энэтхэг-номхон далайн стратеги"-ийг хэрэгжүүлэх болсон явдал гурван улсын эрх ашигт нийцэх тул Шинэ Дэли нааштай хүлээн авах магадлалтай. Гэвч Токио, Вашингтоны стратегид Энэтхэгийг гол үүрэгтэй хэмээн онцолж буй явдал Шинэ Дэлид эдийн засаг, улс төрийн дарамт учирч болох тул БНЭУ болгоомжилж болох талтай. Ялангуяа, БНХАУ-тай харилцахад сорилт үүсч болзошгүй юм.

Учир нь Ш.Абэ 2006-2007 онд Японы ерөнхий сайдаар ажиллахдаа АНУ, Энэтхэг, Австралийг татан оролцуулсан “дөрвөн талт” механизмыг санаачилсан боловч Хятадтай харилцах харилцаанд аюул учирна хэмээн үзэж, Австрали, Энэтхэг улс тус механизмаас гарсан байдаг. Харин эдгээр орны харилцаа гүнзгийрч, гурван талт механизм (АНУ-Япон-Энэтхэг, АНУ-Япон-Австрали зэрэг)-ыг үүсгэн хамтран ажиллах болсон юм. Гэхдээ Ази, Номхон далайн бүс нутаг дахь АНУ-ын оролцоотой гурван талт механизм дийлэнхдээ Хятадыг тогтоон барихад чиглэж байгаа билээ.

2017 оны 12 дугаар сарын 18-ны өдөр танилцуулсан АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын стратегид Ойрхи Дорнод, Европын өмнө Энэтхэг-Номхон далайг онцолсон явдал ирэх жилүүдэд Вашингтоны хувьд стратегийн хамгийн чухал бүс нутаг байхыг нотолж байна. Түүнчлэн уг стратегид Хятад, Орос зэрэг “ревизионист” их гүрнүүд технологи, суртал ухуулга, хүч хэрэглэн Америкийн ашиг сонирхол, үнэт зүйлийн эсрэг дэлхий ертөнцийг үүсгэхийг оролдож байна хэмээн дурдсан юм. Үүгээрээ дээрх хоёр улсыг АНУ-ын өрсөлдөгчид болохыг хүлээн зөвшөөрлөө. Энэ нь Ази, Номхон далайн бүс нутаг их гүрнүүдийн жанжлалын төлөөх тэмцэл өрнөх бүс нутаг болохыг илтгэж байна.

1.1.2. ОХУ-ын ЕАЭЗХ

Кремлийн хувьд ЕАЭЗХ эдийн засгийн гэхээсээ илүүтэй улс төр, геополитикийн ач холбогдолтой тул тус интеграцийг өргөжүүлэх, олон улсын тавцанд голлох үүрэгтэй байгууллага болгохыг эрмэлздэг. Учир нь ЕАЭЗХ бол

АНУ, Европын холбооны нөлөөний эсрэг Төв Азийнхаа хөршүүдээ барьж байх. худалдааны интеграцчлалын төсөл юм. Эдүгээ ЕАЭЗХ бусад улс орнуудтай Чөлөөт худалдааны гэрээ байгуулах хэлбэрээр харилцаагаа өргөжүүлэхийг чармайж байна. ЕАЭЗХ-нд ОХУ тэргүүлэх үүрэг гүйцэтгэх явдал тус холбооны цаашдын хөгжил, ялангуяа тус улсын улс төр, геостратегийн тэлэлтэд саад учруулж болзошгүй гэх болгоомжлол Москвад бий.¹ Үүнийг дараах баримтаар нотлоё.

2017 оны 09 дүгээр сард Казахстаны "Мир Евразии" болон ОХУ-ын "Сибирь-Евразия" шинжээчдийн клуб Евразийн орон зайн интеграцын хөгжлийн сценарын талаар хэлэлцүүлэг явууллаа.^{1 2 3} Оросын улс төр судлаач Эдуард Политаевын хэлснээр ЕАЭЗХ бүрэлдэх явцад гаргаж байсан эерэг таамгуудын ихэнх нь биеллээ олоогүй байна. Тус интеграцын цаашдын хөгжлийн талаар шинжээчид хоёр хуваагддаг. Политаевын үзэж байгаагаар зарим нэг хөгжлийн асуудал тухайлбал нэгдсэн валюттай болох зорилго алс ирээдүй болж хойшилжээ. Шалтгаан нь зөвхөн гишүүн орнуудын эдийн засгийн чадал чансаа янз бүр байгаатай холбоотой төдийгүй тэдгээрийн хоорондын эдийн засгийн харилцаа тэнцвэргүй байгаад оршиж байгаа аж. Хөгжилд саад болж байгаа гол шалтгаанд "тодорхойгүй байдал" тооцогддог байна. Тодруулбал, нэгдсэн валют хэрэгтэй юу үгүй юу, Хятадтай Чөлөөт худалдааны бүс байгуулах уу үгүй юу гэх зэрэг асуудлаар хэлэлцэж нэгдсэн нэг шийдвэрт хүрээгүй гэнэ. Оросын шинжээч Сергей Брюковын үзэж байгаагаар эдгээр болон бусад олон асуудалд хариулт байхгүй, тодорхой үзэл баримтлал, стратеги байхгүй, тэдгээрийг бий болгох тодорхой төлөвлөгөө байхгүй байна. Гаалийн холбоо буюу ЕАЭЗХ нь ЕХ-ны Чөлөөт худалдааны бүс байгуулах гэрээнээс /DCFTA/ хатуу нөхцөлтэй байдгаас гишүүн орнууд өөр эдийн засгийн нэгдэл, байгууллагад нэгдэх, Холбооноос гадуур бие дааж хоёр талын Чөлөөт худалдааны гэрээ хэлцэл хийх боломжгүй, уян хатан бие даасан бодлого явуулах аргагүй байдалд байдаг. '

Герман-Оросын гадаад худалдаа, аж үйлдвэрийн танхимын ЕАЭЗХ-ны орнуудад бодитоор үйл ажиллагаа явуулдаг жижиг дунд бизнес эрхлэгчдийн дунд явуулсан судалгаагаар Гаалийн татвар, шалгалтгүй болгосон явдал бизнес эрхлэхэд мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлсэн гэж үзжээ. ⁴ Тус Холбооны

¹ Дэлгэрэнгүйг хавсралтаас харна уу.

² ЕАЭС: что будет дальше, <http://avesta.tj/2017/09/25/eaes-chto-budet-dalshe/>

³ Судлаачийн зүгээс: Кыргызстан улс БНХАУ-тай байгуулсан хувийн бизнес эрхлэгчид гаалийн татваргүй худалдаа эрхлэх талаарх гэрээ нь журмаас хазайсан ганц тохиолдол юм. Энд Москвагийн зүгээс Кыргызстаныг Холбоондоо нэгтгэхийн тулд хийсэн алхам байх магадлалтай.

⁴ ЕА WU-Umfrage 2017: Deutsche Unternehmen profitieren von der Eurasische Wirtschaftsunion, <http://russland.ahk.de/news/single-view/artikel/eawu-umfrage-2017-deutsche-unternehmen-profitieren-von-der-eurasischen-wirtschaftsunion/>

гишүүдийн хооронд хоёр талын худалдаа голчилж байгаа бөгөөд Лиссабоноос Владивосток хүртэлх нэгдсэн эдийн засгийн нэгдсэн орон зай бий болгох Кремлийн хүсэл биелэгдэх магадлал тун бага, бараг боломжгүй гэж дүгнэжээ.

Тэр дундаа ОХУ ЕАЭЗХ-ны дотооддоо эзлэх хувь хамгийн бага төдийгүй иргэдийн дэмжлэг эрчтэй буурч байгаа нь анхаарал татаж байна. Оросын шинжээчид ОХУ тус Холбооны бага эдийн засагтай орнуудыг геополитикийн үүднээс ЗХУ-ын үеийнх шиг чирч явах шаардлагатай тулгарах бөгөөд энэ нь өөрийнх нь эдийн засгийг хойш татна гэж үздэг.¹ Армян улсын Холбоонд элсэхийг дэмжигчид гэхэд л юуны өмнө хүмүүнлэгийн тусламж авч байх зорилготой байсан.

Өнөөгийн байдлаар Армян улс ЕХ-той Иж бүрэн, гүнзгийрүүлсэн харилцааны гэрээ байгуулах хэлэлцээрээ дуусгавар болж 11 дүгээр сарын 24-нд болох ЕХ-ны "Зүүний түншлэл" саммитын үеэр тус баримтад гарын үсэг зурагдана гэж найдаж байгаагаас* ² гадна Холбооноос гарах тухай сөрөг хүчин ярих болсон юм. Мөн Беларусь улс аажмаар Өрнөдтэй ойртох байдал ажиглагдаж ЕХ-той иж бүрэн, гүнзгийрүүлсэн харилцаа тогтоож Оростой харьцах харилцаагаа тэнцвэржүүлэх бодлого барих хандлагатай болсон.

Түүнчлэн ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын худалдааны алдагдал, инноваци нэвтрүүлэлт бага байгаа явдал өнөөгийн эдийн засгийн загварыг царцмал байдалд оруулах магадлалтай. Гишүүн орнууд гадаад худалдааны бие даасан бодлого явуулах эрх нь хязгаарлагдмал болсонтой холбоотой эдийн засгийн өсөлт буурах эрсдэлтэй болжээ.

ОХУ-ын Ерөнхий сайдын нэгдүгээр орлогч Игорь Шувалов Казахстан улс ЕАЭЗХ-г тэргүүлэх явдал тус Холбооны олон асуудлыг шийдвэрлэхэд ач тустай гэж Москва үзсэн талаар ярьсан мэдээ байна. Тэрээр ОХУ тэргүүлэх үүрэгтэй байх нь интеграцын хөгжилд муу нөлөө үзүүлнэ гэж цохон тэмдэглэжээ.³ Үүнийг Оросууд хөгжил буурай жижиг орнуудыг чирч явсаар ЗХУ нуран унасан гэж дотоодын шинжээчдийн үгтэй холбож ойлгож болох юм. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн хувьд уг интеграцыг хөгжүүлэх сонирхолгүй байгаагийн илрэл. Эсвэл бүр эсрэгээр Холбооны хөгжлийг эрчимжүүлэх, нөлөөний бүс гэж үздэг орнуудыг нэгтгэхийн тулд Кремлийн геополитикийн зорилго гэсэн имижээсээ салахад чиглэсэн үйлдэл байж магадгүй байна. Нөгөө талаас

¹ Судлаачийн зүгээс: Дэлгэрэнгүйг 2017 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн мэдээнээс харна уу.

² Армения между ЕС и ЕАЭС: в ловушке политического паразитизма, <https://ru.armeniasputnik.am/review/20170830/8466317/armeniya-mezhdu-es-eaehs-v-lovushke-politicheskogo-parazitizma.html>

³ Россия признает лидерство Казахстана в ЕАЭС-Шувалов. <http://abctv.kz/ru/last/rossiya-priznaet-liderstvo-kazhastana-v-eaes-shuvalov>

Казахстанд ЕАЭЗХ-оос “залхах” хандлага ажиглагдах болсонтой холбоотой байж болзошгүй юм.

1.1.3. БНХАУ-ын “Бүс ба зам” стратеги

БНХАУ-ын дарга Си Зиньпин 2014 онд “Бүс ба зам” санаачилгыг анх дэвшүүлснээс хойш багагүй амжилтад хүрээд байна. Тухайлбал, дэлхийн 70 гаруй улстай хамтран ажиллахаар тохирч, 30 улстай Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулаад байна. Түүнчлэн энэ санаачилгын хүрээнд АДБХОБ. Торгоны замын сан. ШХАБ-ын Хөгжлийн банк. БРИКС-ийн банк зэрэг хөрөнгө оруулалт, санхүүгийн механизм бүрэлдээд байна.

Хятад ирэх 10 жилд “Бүс ба зам”-ын бүтээн байгуулалтад 1.6 их наяд ам.доллар оруулахаа зарласан бөгөөд голлон дотоодын үйлдвэрлэлийн илүүдлийг шийдвэрлэхэд зориулах ажээ. Тус стратеги Хятадын дотоодын үйлдвэрлэлийг Зүүн өмнөд Ази, Төв Ази зэрэг шинээр хөгжиж буй зах зээлд нэвтрүүлэхэд идэвхтэй дэмжлэг үзүүлэх, улмаар тус бүс нутгуудад оршин суудаг Хятад иргэдийн бодлоготойгоо уяж өгөх нь дараагийн чухал чиглэл байх аж.¹

БНХАУ-ын Төрийн зөвлөлийн мэргэжилтний тооцоолсоноор “Бүс ба зам”-ын бүтээн байгуулалтад 8 их наяд ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай юм. Одоогоор АДБХОБанк, Торгон замын сан, БРИКС-ийн хөгжлийн банкны нийт хөрөнгө 24 сая ам.доллар, өөрөөр хэлбэл Си-гийн амбицтай төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд тус улс хөрөнгийн ноцтой хомсдолд орох эрсдэл байгаа аж.^{*2}

Зарим судлаач тус улс эдийн засгийн өндөр өсөлтийг урт хугацаанд хадгалах боломжгүй бөгөөд хөрөнгийн хомсдолын хямралтай тулгарах эрсдэл буйг анхааруулж байна.³ Үүнд, Хятадын хөрөнгийн гадагшлах урсгал өсч, сорилтыг нэмэгдүүлж байгаа болно. “Нью-Йорк таймс” болон “Bloomberg”-ийн тооцоогоор, өнгөрсөн жил 1 их наяд ам.долларын хөрөнгө гадагш чиглэсэн,

¹ЗӨА-ийн орнууд тус санаачилгад болгоомжтой хандаж буй. Тухайлбал, Тайланд, Хятадын хамтарсан төмөр замын төслийн жишээнээс харвал, Тайландын хувьд тус улсын дэд бүтцийг хөгжүүлэхэд Хятадыг туслаж байна гэж ойлгож байсан бол Хятадаас олгосон зээл өндөр хүүтэй байснаар барахгүй Хятадын талаас тус төмөр замын дагуух газрыг ашиглах эрхийг хүссэнээр тус төслийн зарим хэсэг цуцлагдаад байна. Индонез, Хятадын төмөр замын хамтын ажиллагааны хувьд вагон болон дохиоллын системийн тоног төхөөрөмжийг Хятадын тал нийлүүлэх нөхцөлтэй байгаа юм. https://musou.tw/focuses/l_145

² Тухайлбал, тус улс “Нэг бүс, нэг зам”-ын дагуух улс орнуудын дэд бүтцийн бүтээн байгуулалтад олон төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. үүний дотор Пакистаны баруун хэсэгт боомт байгуулахад зориулсан 50 тэрбум ам.долларын дэд бүтцийн ажил эцэсдээ Хятадын Засгийн газрын эдийн засгийн тусламж болон хувирчээ. Өөрөөр хэлбэл Хятад их мөнгөөр “найрамдал” болон “улс төрийн нөлөөлөл”-ийг худалдан авч байгаа юм.

³2014 онд Хятадын гадаад валютын нөөц дээд цэгтээ хүрч 4 их наяд ам.доллар болсон бол 2015 онд буурч 3.2 их наяд ам.доллар болоод байна. Барууны судлаачдын үзэж буйгаар 2.8 их наяд ам.доллараас доошгүй байж Хятадын санхүүгийн тогтолцоо хэвийн ажиллах ажээ.

цаашид нэмэгдэх аж.¹ Түүнчлэн тус стратегийг хэрэгжүүлэх явцад Хятадын ААН-үүд хилийн чанадад хөрөнгө оруулахад эрсдэл өндөр байгааг мэргэжилтнүүд онцолж байна. Улс орнуудын улс төрийн өөрчлөлт, банк санхүүгийн систем боловсронгуй бус, хууль дүрэм, үйл ажиллагаа эрхлэх арга хэлбэр адил бус зэрэг сорилт тулгарах болно.

БНХАУ одоог хүртэл “Бүс ба зам”-ын нарийвчилсан төлөвлөгөөг тодорхой тайлбарлаагүй байгаа явдал олон улсад эргэлзээ төрүүлсээр байна хэмээн зарим эх сурвалж онцлох нь бий. Гэтэл тус стратеги Хятадын дотоодын үйлдвэрлэлийн илүүдлийг зах зээлд гаргахын тулд дэд бүтцээ хөгжүүлэх, цаашлаад 2049 он гэхэд БНХАУ-ыг дэлхийн хэт их гүрэн болгох, үүнд шаардагдах санхүүгийн эх сурвалж зэргийг тодорхой заасан байгаа. Гагцхүү үүнд дэлхий нийтээрээ бэлэн биш байгаа явдал улс оронд эргэлзээ төрүүлж байна хэмээн үзнэ*². Тус улсын АДБХО³-ын банк зэрэг санаачилга “Бүс ба зам” стратегийг дэмжих төдийгүй дэлхийн санхүүгийн тогтолцооны тоглогч болох, оршин буй санхүүгийн тогтолцоог өөрчлөх БНХАУ-ын стратегийн зорилттой холбоотой байна. Үүнийг дараах байдлаар нотолж болно. Тухайлбал:

Бээжин хотноо 2017 оны 05 дугаар сарын 14-нөөс 15-ны өдөр “Бүс ба зам” олон улсын дээд хэмжээний форум болж өнгөрсөн. Уг форумыг шинэ Хятад улс байгуулснаас хойших БНХАУ-ын гадаад хэргийн түүхэн дэх хамгийн чухал үйл явдал хэмээн Бээжин цохон тэмдэглэсэн юм. Түүнчлэн бүс нутгийн хүчирхэг гүрнээс дэлхийн их гүрэн болох Си төвтэй гадаад бодлогын үр дүнг хэмжих хэмжүүр хэмээн тайлбарлаж байна.

Форумын үеэр Хятадын дарга Си Зиньпиний тавьсан илтгэлээс харахад. Хятад санаачилга дэвшүүлснээс хойших 3 жилийн хугацаанд нийтдээ 30 гаруй улстай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулсан ба хамгийн их үр шим хүртсэн улсаар Казахстан, Пакистан шалгарсан байна. Илтгэлд мөн Хятадын 100 хувийн хөрөнгө оруулалттай Торгоны замын сангийн хөрөнгийг 100 тэрбум, Экспорт импортын банкны зээлийн санг 130 тэрбум юаниар нэмэгдүүлж, “Бүс ба зам”-ын дагуух хөгжиж буй орнууд болон олон улсын байгууллагад 60 тэрбум юаний тусламж. Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагаанд 1 тэрбум ам.доллар, “Бүс ба зам”-ын дагуух хөгжиж буй орнуудад

¹Хятадын Татварын ерөнхий газрын орлогч дарга асан Шү Шаньда, “Нэг бүс, нэг зам”-д оролцож буй Хятадын төрийн өмчит ААН-үүд эцэст нь ноцтой хохирол амсаж болохыг анхааруулсан байдаг. <http://news.ltn.com.tw/news/focus/paper/983067>

² Судлаач Г.Базарваанийн дүгнэлт.

³ Одоогоор бүс нутгийн болон бүс нийт 84 гишүүнтэй болоод байна.

2 тэрбум юаний хүнсий тусламж олгох болсноо зарласан явдал анхаарал татаж байна.¹

Форумд оролцогч 28 улсыг ажиглавал талаас илүү хувь нь БНХАУ-ын хөрш зэргэлдээх, хөрөнгө оруулалт нэн шаардлагатай байгаа, Хятадтай хийх гадаад худалдаандаа алдагдал хүлээдэг Азийн хөгжиж буй орнууд байв. /Хүснэгт 1-ийг үзнэ үү/ Англи, Герман, Франц зэрэг Европын улс оролцоогүйгээс харахад форум тив дэлхийг бүхэлд нь хамарч чадаагүй хэмээн шинжээчид дүгнэж байна.^{1 2}

ТИВ	УЛС
Ази	Индонези, Казахстан, Лаос, Узбекистан, Вьетнам, Камбож, Малайз, Монгол, Мьянмар, Пакистан, Шри Ланк
Европ	Итали, Беларусь, Чех, Орос, Швейцарь, Турк, Грек, Польш, Унгар, Серб
Африк	Кени, Этиоп
Латин Америк	Аргентин, Чили

Хүснэгт 1. Форумд оролцогч орнууд (тивээр)

Европын зарим орноос оролцоогүй тухайд Хятадын гадаад хэргийн сайд Ван И "... тус тивийн зарим оронд улс төрийн сонгууль болоод удаагүй, заримд нь удахгүй сонгууль болох гэж буйтай холбоотойгоор оролцож амжаагүй. Энэ форум эдийн засгийн хамтын ажиллагаа тул улс төржүүлэх шаардлагагүй ..." гэв. Гэвч Англи, Франц, Герман улс эдийн засгийн хөгжлийн тодорхой түвшинд хүрсэн, дэд бүтэц сайтар хөгжсөний дээр газар зүйн байршлын хувьд Хятадаас алслагдмал учир "Бүс ба зам"-д идэвхтэй хамтрах боломж хязгаарлагдмал тул ажиглах байр суурьтай байгаа бололтой.³

Мөн Энэтхэг энэхүү форумд төлөөлөгч илгээсэнгүй харин 2017 оны 05 дугаар сарын 23-нд болсон Африкийн хөгжлийн банкны хурал дээр Японтой хамтран "Ази Африкийн хөгжлийн коридор" (Чөлөөт коридор гэж бас нэрлэдэг)-т хамтран ажиллах болсноо мэдэгдлээ.⁴ Ажиглагчид тус коридорыг "Бүс ба зам"-ыг тэнцвэржүүлэх зорилготой гэж үзэж байна. Учир нь Энэтхэг "Бүс ба зам"-ыг илэрхий шүүмжилдэг цорьш ганц улс бөгөөд Шинэ Делиг тойрсон гео-эдийн засгийн орон зай бий болгохоор тэмүүлж байгаа явдал үүнийг нотолно.

¹ http://news.xinliuane.com/world/2017-05/16/c_129605218.htm

² <https://www.hkq1.com/ffix/85276/—M>

³ ССХ, Францын БХЯ-ын хамтарсан ЭШБХ., 2017.04.28, Парис

⁴ www.ckxxbao.com/huanqishibaodianziban/05261_IR32OI7_15.html

1.2. АНУ, БНХАУ, ОХУ-ын баримталж буй бодлого, хамтын ажиллагааны гол чиглэлүүд, нөлөөлөх хүчин зүйлс, харилцааны цаашдын өрнөлийн төлөв байдлын харьцуулсан таамаглал, үндэслэл

Өмнөх дэд бүлгүүдэд өгүүлсэн АНУ, БНХАУ болон ОХУ-ын “зүтгүүлж” буй стратеги, санаачилгын хүрээнд дурдсан улсын бодлого, хамтын ажиллагаа, өрнөлийн төлөв байдлыг судалгааны ажлын энэхүү дэд бүлэгт дараах байдлаар таамаглан томъёолж авч үзлээ.

ЭНЭТХЭГ-НОМХОН ДАЛАЙН СТРАТЕГИ АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮС НУТАГ ДАХЬ ИХ ГҮРНҮҮДИЙН ӨРСӨЛДӨӨНИЙГ ГААРУУЛНА.

Энэтхэг-Номхон далайн бүс нутаг АНУ-ын стратегийн хүндийн твв болно. 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдөр танилцуулсан АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын стратегид Ойрхи Дорнод, Европын өмнө Энэтхэг-Номхон далайг онцолсон явдал ирэх жилүүдэд Вашингтоны хувьд стратегийн хамгийн чухал бүс нутаг байхыг харууллаа. Түүнчлэн уг стратегид Хятад, Орос зэрэг "ревизионист" их гүрнүүд технологи, суртал ухуулга, хүч хэрэглэн Америкийн ашиг сонирхол, үнэт зүйлийн эсрэг “дэлхий ертөнц”-ийг үүсгэхийг оролдож байна хэмээн дурдсан юм. Үүгээрээ дээрх хоёр улсыг АНУ-ын өрсөлдөгчид болохыг хүлээн зөвшөөрлөө.

Энэтхэг-Номхон далайн стратеги бол АНУ-ын дахин тэнцвэржүүлэх¹ бодлогын үргэлжлэл болно. Азийн орнуудад хийсэн айлчлалын хүрээнд Вьетнамын Да нанг хотноо болсон АПЕК-ийн уулзалтад үг хэлэхдээ АНУ-ын Ерөнхийлөгч Д.Трамп “Энэтхэг-Номхон далай”-н стратегиа танилцууллаа. Энэ удаад Вашингтон Нью Дэлдид ач холбогдол өгч Бээжингийн өсөн нэмэгдэж буй нөлөөг хязгаарлах зорилго агуулж байна. Үүгээр энэ стратегийг өмнөх ерөнхийлөгчийн хэрэгжүүлж байсан Хятадыг тогтоон барих зорилго бүхий "дахин тэнцвэржүүлэх" бодлогын үргэлжлэл хэмээн дүгнэж болохоор байна. Гэхдээ энэхүү стратеги Энэтхэг-Номхон далай хэмээх нэр томъёог ашиглах болсон төдийгүй Энэтхэг зэрэг ардчилсан түншүүдэд түлхүү чиглэж байгаагаараа “дахин тэнцвэржүүлэх” бодлогоос ялгаатай болно.

¹ Ерөнхийлөгч Б.Обамагийн засаг захиргаа Ази, Номхон далайн бүс нутаг дахь АНУ-ын оролцоо, нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор “дахин тэнцвэржүүлэх” бодлого хэрэгжүүлэхээ зарласан. Энэ нь Вашингтон 2001 оны есдүгээр сарын 11-нээс хойш улс төр, батлан хамгаалах бодлогынхоо цөмийг Ойрхи Дорнод руу шилжүүлсэн байсныг өөрчилсөн алхам болов. Ийнхүү "стратегийн хүндийн төв" өөрчлөгдсөнөөр Номхон далай, Атлантын далайд 50:50 харьцаатай байрласан АНУ-ын тэнгисийн цэргийн хүчээ 2020 он гэхэд 60:40 харьцаатай болгон өөрчлөн байрлуулахаа мэдэгдсэн билээ.¹ Хэднйгээр тухайн үед Вашингтон энэ бодлогыг Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн ач холбогдол өссөнтэй холбоотой тайлбарлаж байсан хэдий ч угтаа өсөн нэмэгдэж буй Хятадын нөлөөг хязгаарлах зорилготой байсан билээ.

Энэтхэг-Номхон далайн стратегийг БНЭУ нааштай хүлээн авах магадлалтай байна. БНЭУ-ын Ерөнхий сайд Н.Моди “Дорно руу хандах бодлого” (Act East Policy) хэрэгжүүлж, Зүүн Азийн орнуудтай бүхий л салбарт харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар Хятадын өсөн нэмэгдэж буй нөлөөг хязгаарлахыг оролдож байна. Үүнтэй зэрэгцэн Япон, АНУ-ын зүгээс ижил зорилго бүхий Энэтхэг-Номхон далайн стратегийг хэрэгжүүлэх болсноор гурван улсын стратегийн ашиг сонирхол давхцаж байна. Энэхүү ашиг сонирхлын давхцалаас үзэхэд Энэтхэг-Номхон далайн бүс нутагт чиглэсэн Япон, АНУ-ын стратегийг Энэтхэгийн тал нааштай хүлээн авах магадлалтай болно. Гэвч Токио, Вашингтоны дээрх стратегид Энэтхэгийг гол үүрэгтэй хэмээн онцолж буй явдал Нью Делид эдийн засгийн болон бусад дарамт үзүүлж магадгүй хэмээн БНЭУ давхар болгоомжилж байж болзошгүй.

Энэтхэг-Номхон далайн стратеги гурав болон дөрвөн талт хамтын ажиллагааны механизмд тулгуурлана. Шинзо Абэ 2006-2007 онд Японы Ерөнхий сайдаар ажиллахдаа АНУ, Энэтхэг, Австралийг татан оруулсан “дөрвөн талт” механизмыг санаачилсан боловч Хятадтай харилцах харилцаанд аюул учирна хэмээн үзэж, Австрали, Энэтхэг тус механизмаас гарсан байдаг. Гэхдээ эдгээр орны хоёр талт харилцаа гүнзгийрч, гурван талт механизмууд (АНУ-Япон-Энэтхэг, АНУ-Япон-Австрали зэрэг) аажмаар урагшилж байв. Энэтхэг-Номхон далайн стратегийг АНУ-ын гадаад бодлогод тэргүүлэх чиглэл болоход, цаашид энэ бүс нутагт АНУ-ын холбоотны харилцаа бэхжихэд Япон чамгүй идэвх зүтгэл гаргана.

АНУ-ын зүгээс өврийн оролцоотой гурван талт механизмуудыг аюулгүй байдлын зорилгод ашиглах эрсдэлтэй. Ази, Номхон далайн бүс нутаг дахь АНУ-ын оролцоотой гурван талт механизмууд дийлэнхдээ Хятадыг тогтоон барихад чиглэж буйгаас үзэхэд Монгол-АНУ-Япон болон шинээр үүсгэхээр төлөвлөж буй Монгол-АНУ-Энэтхэгийн гурван талт хамтын ажиллагааг ийм зорилгод ашиглах эрсдэлтэйг анхаарах нь зүйтэй. Иймд дээр дурдсан механизмд Монгол Улс оролцохдоо АНУ, Япон, Энэтхэгтэй эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд анхаарч, БНХАУ болон бусад улс орны аюулгүй байдлын ашиг сонирхлыг хөндсөн үйл ажиллагаанд оролцохоос зайлсхийх нь зөв. Түүнчлэн, АНУ болон бусад “Туравдагч хөрш”-ийн оролцоотой гурван талт механизмын түвшинг Гадаад харилцааны сайд нарын уулзалтаас дээш ахиулахгүй байваас зохилтой,

Гурван талт механизмаар дамжуулан АНУ, Япон газар нутгийн маргаанд Монгол Улс тэднийг дэмжсэн байр сууриа илэрхийлэхийг шахах магадлалтай. АНУ болон Японы зүгээс Өмнөд Хятадын тэнгис дэх газар нутгийн маргааныг олон талт механизмын хүрээнд олон улсын эрх зүйд

тулгуурлан шийдвэрлэх ёстой хэмээн үздэг бол Хятад асуудлыг хоёр талын хүрээнд авч үзэх сонирхолтой байдаг. Ийнхүү газар нутгийн маргааныг шийдвэрлэх арга зам тус бүр өөр байгаагаас асуудал даамжирч¹, талууд өнөөг хүртэл шийдэлд хүрч чадахгүй байна. Олон талт механизмуудын хүрээнд газар нутгийн маргааныг шийдвэрлэх зорилгоор АНУ, Японы зүгээс манай улсыг тэднийг дэмжсэн байр суурь илэрхийлэхийг шахаж болзошгүй юм. АНУ-ын засаг захиргаа Иерусалимыг Израилийн нийслэлээр хүлээн зөвшөөрсөн явдлыг буруушаасан НҮБ-ын тогтоолыг дэмжиж санал өгсөн улс оронд тусламж үзүүлэхээ зогсооно хэмээн Ерөнхийлөгч Д.Трамп заналхийлсэн (Shugerman. 2017). Үүнээс үзэхэд энэ мэт олон улсын маргаантай асуудалд АНУ-ын талыг баримтлаагүй тохиолдолд Вашингтон эдийн засгийн хүч нөлөөгөө ашиглан улс орнуудыг шахалтанд оруулах магадлалтай байна.

ХЯТАД МӨРӨӨДЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ “БҮС БА ЗАМ” СТРАТЕГИ БҮЮУ “ТОРГОН ТОР”-ЫН БОДЛОГО ЭРЧЭЭ АВНА.

ХКН-ын 100 жилийн ой тохиоход /2021 он/ дунд орлоготой улс, БНХАУ-ын 100 жилийн ой тохиоход /2049 он/ баян чинээлэг, дэлхийн их гүрэн болох зорилгыг БНХАУ өмнөө тавьсан. Үүнийг Хятад мөрөөдөл хэмээн томъёолж, түүнд хүрэх арга зам, тактик, стратегийг хэрэгжүүлж байна. Хятад мөрөөдлийг хэрэгжүүлэх гол стратеги бол “Бүс ба зам” юм.

“Бүс ба зам” бол БНХАУ-ын жнн нөлөөг бүс нутаг, цаашлаад дэлхийд бэхжүүлэх зорилготой худалдаа, эдийн засаг, дэд бүтэц, “зөөлөн хүч”-ний бодлогыг холбосон стратеги болно. БНХАУ-ын дарга Си Зиньпин 2014 онд “Бүс ба зам” санаачилгыг анх дэвшүүлснээс хойш дэлхийн 71 улстай хамтран ажиллахаар тохирч, 30 улстай хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зураад байна. Энэ санаачилгын хүрээнд АДБХОБ, Торгоны замын сан, ШХАБ-ын Хөгжлийн банк, БРИКС-ийн банк зэргийн санхүүгийн механизм бүрэлдээд байна. Мөн Хятадын түүх соёл, хэл бичгийг сурталчлан таниулах, дэлгэрүүлэх үүднээс Күнзийн сургалтын төвүүдийг олон улсад нээж, хятад судлалыг бодлогоор дэмжиж, үнэ төлбөргүй хятад хэл, соёл, түүхийн чиглэлээр сургалтыг явуулж байна. Түүнчлэн БНХАУ-ын Сангийн яам. Хөгжил шинэтгэлийн хорооноос “Бүс ба зам”-ыг сурталчлан таниулах сургалтыг тогтмол зохион байгуулж байна.

¹АНУ-ын Батлан хамгаалах яамнаас гаргасан тайланд дурдсанаар 2013 оны 12 дугаар сараас 2015 оны 6 дугаар сарын хооронд Өмнөд Хятадын тэнгист БНХАУ 2,900 акр (1.170 га) хиймэл арал байгуулсан. Үүнээс өмнө Хятад 2,000 акр (890 га) хиймэл арал байгуулаад байсан юм. Хятадын сүүлийн 20 сард байгуулсан хиймэл арлын хэмжээ газар нутгийн маргаанд оролцогч бусад улсын 40 гаруй жил байгуулснаас илүү төдийгүй нийт шинээр байгуулсан хиймэл арлуудын 95 хувийг Хятад дангаараа бүтээн байгуулжээ. (Reuters “China’s land reclamation in South China Sea grows: Pentagon report. Aug 21,2015)

"Бүс ба зам" стратеги эдийн засгийн харилцааны шинэ дэг журмыг үүсгэж болзошгүй. АНУ-ын эдийн засаг, байр суурь, ерөнхийлөгч Д.Трампын гадаад бодлогын тодорхойгүй байдлын улмаас БНХАУ-ын нөлөө олон улсын харилцаанд улам бүр нэмэгдэж байна. "Бүс ба зам" худалдаа, хөрөнгө оруулалтын стратеги улам бүр глобалчлагдаж, эдийн засгийн өсөлт сул улс орон Хятадаас хөрөнгө оруулалт татахын тулд Бээжинг аялдан дагах хандлага хэдийнээ бэхжээд байгаа. Хэдийгээр аливаа улсын дотоод хэрэг, эдийн засгийн амьдралд оролцохгүй, нөлөөлөхгүй, энхийг эрхэмлэсэн, харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэх тухай БНХАУ олонтаа мэдэгдэж буй ч бодит байдалд аль нэг улсад оруулсан хөрөнгөөр босгох бүтээн байгуулалтын ажлыг Хятадын ААН гүйцэтгэх, тус улсын технологийг ашиглах зэрэг нөхцөлийг тулгах худалдаа, эдийн засгийн шинэ дэг журмыг Бээжин үүсгэж болзошгүй байна.

Энэтхэг-Ази номхон далайн стратеги бол "Бүс ба зам" стратегийг сөрөх, Хятад мөрөөдлийг тогтоон барих бодлого болно. Азийн орнуудад хийсэн айлчлалын хүрээнд Вьетнамын Да нанг хотноо болсон АПЕК-ийн Дээд хэмжээний уулзалтад үг хэлэхдээ АНУ-ын Ерөнхийлөгч Д.Трамп "Энэтхэг-Номхон далай"-н стратегийг танилцуулсан. Үүнд Шинэ Дэлийн үүрэг оролцоо ихээхэн чухал болохыг онцолсон. Үүний дараа АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын шинэ стратегид¹ Энэтхэг-Номхон далайг мөн онцолсон явдал ирэх жилүүдэд Вашингтоны хувьд стратегийн хамгийн чухал бүс нутаг байхыг харуулж байна. Уг стратегид Хятад, Орос зэрэг "ревизионист" их гүрнүүд технологи, суртал ухуулга, хүч хэрэглэн Америкийн ашиг сонирхол, үнэт зүйлийн эсрэг "дэлхий ертөнц"-ийг үүсгэхийг оролдож байна хэмээн дурдсанаас үзвэл "Энэтхэг-Номхон далай"-н стратеги бол Еврази төдийгүй АНД бүс нутагт Орос, Хятадын нөлөөг тогтоон барих стратеги болно.

"Бүс ба зам" стратегийг хэрэгжүүлэх гол арга зам бол ЭЗК-ийг үүсгэх явдал болно. "Бүс ба зам" стратегийн хүрээнд БНХАУ-аас санаачилж буй эдийн засгийн зургаан коридор бий. Эдгээр нь харилцан адилгүй ашиг сонирхлыг илэрхийлдэг. Тухайлбал, Хятад-Пакистаны коридор газрын тосны тээвэр хийх, Шри Ланка-Хятад-Энэтхэг-Хятад-Мьянмарын коридор АСЕАН-ы орнуудтай эдийн засгийн харилцаагаа өргөтгөх, Монгол-Хятад-Оросын коридор эрчим хүчний салбарт хамтран ажиллах зорилгыг агуулж байна. Үүнээс Монгол-Хятад-Оросын коридор бусад коридортой харьцуулахад дотооддоо тогтвортой, тайван, цөөн улсаар дайран өнгөрөх Европ-Азийг холбосон хамгийн дөт маршрут гэдгээрээ давуу талтай юм. Иймээс Бээжингийн зүгээс Хятад-

¹2017 оны 12 дугаар сарын 18-ны өдөр танилцуулсан.

Пакистан, Хятад-Монгол-Оросын ЭЗК-ийг жишиг коридор болгон хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

“Бүс ба зам” стратеги юаньд суурилсан санхүүгийн тогтолцоог үүсгэж болзошгүй. Хятадын юань 2016 оны 10 дугаар сарын 01-ний өдөр Олон улсын валютын сангийн тусгай зээлжих эрх (SDRj-тэй валютын сагсанд албан ёсоор орсон. Түүнчлэн ОХУ-тай хийх худалдааны гүйлгээг үндэсний мөнгөн тэмдэгтээр гуйвуулах банк хоорондын шилжүүлгийн CFETS ¹ системийг БНХАУ бий болгосноо мэдэгдсэн. Энэхүү шилжүүлгийн системээр ОХУ-тай гүйлгээ хийхийг Хятадын Төв банк зөвшөөрсөн* ² . Ингэснээр хоёр улсын хооронд хийх худалдааны төлбөрийг рубль болон юаньд хөрвүүлэн шилжүүлэх боломжтой болсон төдийгүй олон улсын худалдаанд ноёрхох ам.долларыг шахаж, үндэсний валютын хөрвөх чадварыг нэмэгдүүлэхээр зорьж байна. Цаашид энэхүү системээр “Бүс ба зам” төсөлд оролцох бүх улстай гүйлгээ хийхээр төлөвлөж буй³ явдал “Бүс ба зам” стратегийн хүрээнд юань голлох валют болж болзошгүй байна.

“Бүс ба зам”, ЕАЭЗХ-г нэгтгэх талаар ярьж байна. “Бүс ба зам” болон ЕАЭЗХ-г нэгтгэх явдал Хятад, Оросын аль алинд нь ашигтай. Хятадын тухайд “Бүс ба зам” хэрэгжих таатай нөхцөлийг бүрдүүлэхэд Оросын нөлөө хэрэгтэй бол Оросын тухайд Төв Азийн улс орнуудад дэглэмийг хадгалж үлдэх, эдийн засгийг нь тогтворжуулахад БНХАУ-ын оролцоо ач холбогдолтой байна. Евразийн бүс нутсаг дахь Хятад, Оросын ашиг сонирхлын нэгдэл онцгой хяналттай геополитикийн орон зайг бий болгох суурийг тавьж байна. Ази номхон далайн бүсэд ч ялгаагүй Орос, Хятад харилцан бие биеэ дэмжиж байна. Орос-Хятадын энэхүү ойртолт цаашид олон улсын харилцааны одоогийн дэглэм тэсч үлдэхэд ихээхэн сорилт учруулж болзошгүй байна.

ЕАЭЗХ, БНХАУ-ЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА ӨРГӨЖИНӨ.

БНХАУ-тай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх тал дээр ЕАЭЗХ идэвхтэй ажиллаж байна. 2016 оны 6 дугаар сард Евразийн эдийн засгийн комисс /цаашид ЕАЭЗК гэх/ болон БНХАУ-ын хооронд “Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээр” хийх талаар яриа, хэлцэл эхлүүлж, хамтарсан мэдэгдэл гаргасан юм. Мөн оны 8 сард ЕАЭЗК тэргүүлэгч Тигран Саркисян Хятадад албан ёсны айлчлал хийсэн явдал хамтын ажиллагаанд ихээхэн түлхэц өгчээ. Анхны албан ёсны яриа хэлцэл 2016 оны 10 дугаар сард болж, харилцааны шинэ институт, шинэ салбарыг бий болгох

¹ China Foreign Exchange Trade System

² 2017 оны 10 дугаар сарын 09-ний өдөр

³ “Россия и Китай создали международную платёжную систему исключаящую участие доллара”. Автор: Редакция ИА “Госновости”. gosnovosmi.com/2017/10/россия-и-китай-создали-международную/. 12.10.2017

зорилго тавьсан. Түүнчлэн талууд худалдааг эрчимжүүлэх, үүний тулд тарифын бус саад тотгорыг бууруулах, худалдааны нөхцөлийг илүү тогтвортой. урьдчилан харах боломжтой болгох, эдийн засгийн бүхий л салбарт хамтран ажиллах шинэ санаачилгыг дэмжих зорилго тавьжээ. 2016 оны 12 дугаар сарын 20-нд анх удаа ЕАЭЗК ба ЕАЭЗХ-ны Ажил хэргийн зөвлөлийн хамтарсан зөвлөлдөх уулзалт болж Хятад улстай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хэрхэн хөгжүүлэх талаар хэлэлцэн хамтын ажиллагааны жагсаалтыг салбар тус бүрээр гаргасан байна.

БНХАУ-тай гаалийн салбарт хамтран ажиллах тухай яриа хэлэлцэж байна. Гаалийн мэдээллийг солилцох асуудлаар хэлэлцээр хийх талаар талууд ярилцаж байна. Түүнчлэн Хятадын Үндэсний хөгжил шинэчлэлийн хороотой өрсөлдөөний эсрэг бодлого, өрсөлдөөний эсрэг ажиллагааг зохицуулах салбарт хамтран ажиллах талаар Санамж бичиг байгуулсан. Үүнээс гадна ЕАЭЗХ болон Эдийн засгийн Торгоны замын төслийн хооронд харилцааг хөгжүүлэхийг хичээж байна. Энэ зорилгоор тээвэр болон дэд бүтцийн салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулсан бөгөөд ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын тухайн салбарын тэргүүн нарын 2016 оны 12 дугаар сарын 5 дахь хуралдаанаар дээрх салбарт хамтран хэрэгжүүлэх төслүүдийн тэргүүлэх жагсаалтыг баталсан байна.

ЕАЭЗХ болон БНХАУ-ын харилцаа, хамтын ажмллагаа институтчиглагдаж байна. ЕАЭЗХ болон БНХАУ-ын хооронд худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээг албан ёсоор эцэслэж 2017 оны 10 дугаар 01-нд Хэлэлцээрт гарын үсэг зурсан талаар БНХАУ-ын Худалдааны сайд Чжун Шань, ЕАЭЗК-ын худалдааны сайд Вероника Никишин нар хамтарсан мэдэгдэл хийсэн. Үүгээр хоёр тал анхны институтчлагдсан шинжтэй хэлэлцээр байгууллаа хэмээн мэдэгдэж байв. Энэ нь ЕАЭЗХ болон Хятадын Эдийн засгийн Торгоны зам төсөл харилцан уялдаатай ажиллах талаарх 2015 оны 5 дугаар сард БНХАУ-ын дарга Си Зиньпин, ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин нарын байгуулсан хэлэлцээр хэрэгжихэд түлхэц болох аж, Уг хэлэлцээрийн ач холбогдол талууд аажмаар тарифын бус саад тотгорыг бууруулах, худалдааг дэмжихэд чиглэсэн тодорхой ажил хэрэгжүүлэх, үйлдвэрлэл хөгжүүлэх таатай орчин бүрдүүлэх, ЕАЭЗХ болон Хятадын Эдийн засгийн Торгоны зам төсөл харилцан уялдуулах үйл явцад түлхэц өгөхөд орших гэнэ. Гэхдээ энэ нь Чөлөөт худалдааны хэлэлцээр биш бөгөөд зөвхөн зарим нэг худалдааны хязгаарлаж байгаа хүчин зүйлийг бууруулахад чиглэж байгаа юм. ЧХХ байгуулах хүртэл ахиад олон жил удаан хугацааны яриа хэлцэл хийх шаардлагатай талаар хоёр талын мэргэжилтнүүд онцолдог.

ЕАЭЗХ-ны тээвэр-логистикийн асуудлыг БНХАУ сонирхож байна.

Тус Холбооны санал болгосон тээвэр, дэд бүтцийн хамтын ажиллагааны талаар Хятадын тал судалж байгаа талаар мэдэгддэг. ЕАЭЗХ-ны гишүүн орнууд тус салбарт хамтран ажиллах, Хятадын хөрөнгө оруулалтыг татах 38 төсөл санал болгосон байдаг. Хятад-ЕАЭЗХ-ЕХ-ын тээвэр логистикийг бий болгох, Баруун Европ "Хятадын баруун хэсэг-хойд-өмнө. Зүүн-Баруун ба Хойд тэнгисийн зам гэсэн тээврийн коридорт нэгдэх төслүүд санал болгосон. Хятадын тал Архангельскийн гүн усны боомт байгуулах болон Цагаан тэнгис-Коми-Урал-/Белкомур/ чиглэлийн төмөр зам барих төслийг сонирхож байгаа. "Белкомур" төмөр замын магистрал нь Хятадаас Европ руу болон үйлдвэрлэлийн бүс болох Урал, Сибирь, Казахстан болон Монголд бараа бүтээгдэхүүн контейнороор тээвэрлэхэд шаардлагатай гэж Хятадууд үзэж байгаа талаар мэдээ байна. Архангельскийн боомт нь Хятадыг Европ, АНУ-ын зүүн эрэгтэй холбох птінэ замыг нээж өгөх аж. /Зураг харах/ Ийнхүү 38 төсөл санал болгосноос 2 төслийг сонирхохоо БНХАУ илэрхийлж буй явдал Орос-Хятадын харилцаанд Бээжин өөрийн бодлого тулгах магадлалтай байна.

ЕАЭЗХ-ны асуудлыг ОХУ бие даан шийдэж байна. Тус холбооны гишүүн орнууд Хятадтай харилцаа нягтрах тусам дотоодын үйлдвэрлэлд нь томоохон сорилт учирна хэмээн ихээхэн болгоомжилж байгаа ч Москва эдийн засгаа тэлэхийн тулд ЕАЭЗХ нэрийн дор бусад улстай харилцаагаа өргөжүүлэх бодлого явуулаад багагүй хугацаа өнгөрсөн. Олон улсын болон Оросын зарим шинжээчид ОХУ, БНХАУ-ын хоорондын хамтын ажиллагаа бүхий л нөөцөө шавхсан, зөвхөн улс төрийн салбарт том том мэдэгдлүүд гарч байгаагаас эдийн засгийн салбар, хөрөнгө оруулалтын салбарт юу ч хөдлөхгүй байгаа талаар шүүмжлэх болсон.

Иймээс Хятадын албаны хүмүүс хамтын ажиллагааны шинэ салбарыг нээх хэрэгтэй гэж мэдэгдэж байсан. Энэ нь Орос, Хятадын хэн хэн нь бодит байдал дээр итгэлцэл зөвхөн улс төрийн түвшинд байгаагийн илэрхийлэл бөгөөд ЕАЭЗХ-ны хүрээнд л харилцаагаа өргөжүүлэх боломжтой хэмээн харж буй бололтой.

ОХУ БОЛОН БНХАУ-ЫН ХАРИЛЦААГ ШХАБ БЭХЖҮҮЛНЭ.

ШХАБ-ын эдийн засгийн хамтын ажиллагаа сул хэвээр байна. 2017 онд Астанад болсон Дээд хэмжээний уулзалтаар эдийн засгийн хамтын ажиллагааны чиглэлд дараах асуудалд анхаарахаар тусгажээ. Үүнд:

- Бээжингийн санаачилгыг бүрэн дэмжиж, "Бүс ба Зам"-ын хүрээнд ШХАБ-ын орнууд харилцан ашигтай хамтран ажиллах.

- Интеграцийн хүрээний төслүүдийг санхүүжүүлэх тогтсон бүтэцтэй болохын тулд ШХАБ-ын Хөгжлийн фонд, Хөгжлийн банк байгуулах асуудлыг шинжээчдийн түвшинд авч үзэж, ул суурьтай шийдвэрлэх,

- Тээвэр, дамжин өнгөрүүлэхийг хөнгөвчлөхийн тулд "Олон улсын авто замын тээвэрт таатай нөхцөл бүрдүүлэх тухай" ШХАБ-ыг орнуудын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах,

- Олон талт эдийн засгийн төслүүдэд ШХАБ-ын Банк хоорондын нэгдэл болон Ажил хэргийн зөвлөлийн идэвхтэй оролцоо чухал болохыг тус тус онцолсон байна.

Эдгээр нь бодит эдийн засгийн төсөл хөтөлбөрийн санал, санаачилга гэхээс илүүтэй уриалга, тунхаглалын шинжтэй байгаа явдал эдийн засгийн хамтын ажиллагаа ШХАБ-ын гишүүдийн хооронд сул байгааг илтгэнэ.

Орос, Хятад хоёр ШХАБ-ын хүрээнд аюулгүй байдлын асуудлаа чухалчилна. Бүс нутагт аюулгүй, тогтвортой байдлыг бэхжүүлэхэд нэн тэргүүнд анхаарах нь интеграцийн гол зорилго тул энэ хүрээнд олон улсын терроризм, сепаратизм, экстремизмийн эсрэг хамтран тэмцэхээ талууд интеграцийн хүрээнд төдийгүй хоёр талын уулзалт бүрт, бүх түвшиндээ мэдэгдэж байна.

Одоогийн байдлаар ШХАБ гадаад хамтын ажиллагааныхаа чиглэлд дараах асуудалд анхаарал хандуулж байна. Үүнд:

- ШХАБ-ын ажиглагч улс-Афганистаны асуудлын гол зохицуулагч нь НҮБ байна гэж үзэж байгаагаараа **НА ТО-гийн оролцоог хязгаарлах;**

- Сирийн асуудлыг шийдвэрлэхдээ Казахстаны зуучлал болох Астанагийн процессийн үүрэг, оролцоог чухалчилснаараа **Женевийн хэлэлцээрийн ач холбогдлыг бууруулах;**

- Ажиглагч улс-Ираны цөмийн хөтөлбөрийг тойрсон асуудлыг Иран, ЕХ-г багтаасан “зургаагийн бүлгийн” хүрээнд шийдвэрлэхийг онцолж байгаа явдал **Вашингтоны хүслээр болохоос сэргийлэх;**

- Украины хямралыг Минскийн зөвшилцлийг хэрэгжүүлэх замаар шийдвэрлэнэ гэнснээрээ **Кремль байр сууриа хадгалж үлдэхийг** тус тус зорьж байгаа явдал олон улсын амьдралд АНУ тэргүүтэй эвслийнхний үүрэг, нөлөөг хязгаарлаж, Орос, Хятадын хамтын оролцоог бэхжүүлэхээр чармайж буйг илтгэнэ.

ШХАБ-ын хоёр гол хүчин байсаар ирсэн ОХУ, БНХАУ-ын нөлөө, жин цаашид ч интеграцийн хүрээнд хэвээр хадгалагдана. Талууд 2016 онд “Сайн хөрш, найрамдал, хамтын ажиллагааны гэрээ”-нийхээ 15 жилийн ойг угтан “Шинэ торгоны зам”, ЕАЭЗХ зэрэг эдийн засгийн бодит төсөл, хөтөлбөр, санаачилгыг уялдуулж, хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэхээр тохирсон билээ.

Торгоны замын эдийн засгийн бүсийг ЕАЭЗХ-той холбох “замын зураглал”-ыг бэлэн болгохоор ажиллаж байгаа. ЕАЭЗХ-ны Комиссийн дарга Виктор Христенкогийн мэдээлснээр, 2016 оны эхний хагаст “замын зураглал”-ын төслийг бэлдээд 2017 онд Хятадын талтай тохиролцон баталгаажуулж, бэлэн болгохоор төлөвлөсөн байна. Мөн Гаалийн холбоо байх үед үйлчилж байсан Гаалийн кодексийн шинэ журам үйлчилж эхэлсэн ба ингэснээр холбооны гишүүдийн хооронд гаалийн нэгдсэн нэг зохицуулалттай болохоос гадна гаалийн бүрдүүлэлт, үйлчилгээг цахимжуулах бодлого баримталж байна. В.Путин Хятадтай давхар татварыг цуцлах зөвшилцөлд гарын үсэг зурсан явдал мөн энэ чиглэлд хийж буй томоохон алхам юм. Баримт бичиг 2017 оны 1 дүгээр сараас хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн ба ингэснээр талууд хоорондоо төдийгүй бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд эдийн засгийн харилцаагаа өргөжүүлэх боломжтой болох аж.

Төв Азийн бүс нутаг дахь олон талт хамтын ажиллагааны механизмуудын үйл ажиллагаа бүс нутагт нөлөө бүхий гүрэн болох ОХУ, БНХАУ-ын идэвх, санаачилгаас шууд шалтгаална. Сүүлийн жилүүдэд бүс нутгийн олон талт хамтын ажиллагааны хүрээнд өрнөсөн зарим нэг үйл явцаас үзвэл манай хоёр хөрш тэдгээр дэх оролцоогоороо дамжуулан бүс нутагт нөлөөгөө тэлэх, түншлэлээ бэхжүүлэхээр зорьж байна.

Орос, Хятад хоёр өөрсдийн санаачилсан томоохон төслүүдээ уялдуулж, холбон урагшлуулах сонирхолтой байна. Бүс нутгийн нөхцөл байдлаас үүдэн аюулгүй байдлын асуудлаа ШХАБ болон ХАБГБ-ын хүрээнд хариуцуулахаар ерөнхийдөө тохирч байгаа бол ЕАЭЗХ-г “Торгоны зам”-ын эдийн засгийн бүстэй холбон эдийн засгийн зорилтуудаа шийдвэрлэхээр зорьж байна.

¹ “Дорожную карту”, касающуюся зоны свободной торговли ШОС, готовят в течение полугодия., bc-sco.org/?level=10&id=2094&lng=ru